

Memoria saecularis Sakari Palsi

Aufzeichnungen von einer Forschungsreise nach der nördlichen Mongolei im Jahre 1909
 Herbst Bibliographien bearbeitet und herausgegeben von Harry Helen Helsinki 1982.

Сакари Пэлзи-гийн эрин зууны дурсамж

1909 онд хойт Монголд хийсэн шинжилгээний аялалын тэмдэглэл, ном зүйн хамт. Эмхлэн бэлтгэж гаргасан Харри Хален. Хельсинки 1982

1982 онд Хельсинкид герман хэлээр хэвлэгдсэн энэ ном 202 хуудас, 263 зурагтайгаас гадна, аялалынхаа 1 газрын зураг хавсаргажээ. Финландын эрдэмтэн доктор Сакари Пэлзи бол археологч, угсаатны зүйч, шинжилгээ-судалгааны хайгуулч, музейн цуглуулагч, фото-зурагчин, зохиолч зэрэг олон талтай асар их бүтээлийн сан хөмрөг үлдээсэнээрээ финландын ард түмэн ба финланд эх орондоо алдаршсан юм.

Харин 1909 онд С. Пэлзи-гийн монголд хийсэн шинжилгээний хайгуулийн тухай, бүтээл одоогоос 70 гаруй жилийн өмнө 1911 онд, мөн 40 жилийн өмнө 1949 онд хоёр дахь удаагаа зөвхөн фин хэлээр хэвлэгддэн гарч байжээ. 1909 онд Монголд явуулсан шинжилгээний ажил «Фин-Угорийн нийгэмлэг»-ээс тэр үед тус нийгэмлэгийн ерөнхийлөгч байсан финландын сенатын гишүүн Отто Донеерын удирдлагаар гаргасан ажлын төлөвлөгөөний дагуу, юуны өмнө хуучин түрэг бичээс хайх ба булшуудыг бололцооныхоо хэрээр ухаж судлах зорилт тавьсан байна. Мөнхүү хайгуулийн ажилд С. Пэлзигээс гадна Г. Ж. Рамстедт хамтран явсан юм. Фин-Угорийн нийгэмлэгийн 1910 оны ажлын тайланд, С. Пэлзи, Г. Ж. Рамстедт нарын монголд хийсэн аялалын археологи, угсааны зүй ба газар зүйн материалыг хянаж, хэвлэлд бэлтгэх тухай заалт өгсөн байна. Тэр шийдвэрийн дагуу Г. Ж. Рамстедт уг материалыг хянаж, хэвлэлд бэлтгэсэн ба мөн материалын герман хэлээрх бичмэл эхийг хэвлэхийг тус нийгэмлэг 1912 оны 2-р сарын 18-нд зөвшөөрчээ.

Гэвч 1909 онд С. Пэлзи, Г. Ж. Рамстедт нарын монголд хийсэн шинжилгээний хайгуулын материал, бүрэн цогцлогдон эрдэм шинжилгээний энэхүү ном болж, 1982 онд хэвлэгдэх хүртлээ урт удаан зам туулжээ. Энэ тухай уг номын оршилд тэмдэглэсэн зарим баримтаас товчлон дурьдвал:

—С. Пэлзи Монголд хийсэн аялалынхаа материал, аяны өдрийн тэмдэглэл, холбогдох захидлууд болон фото зургуудыг нэгтгэн 1911 онд нэг ном болгон хэвлэлд бэлтгэсэн боловч эрдэм шинжилгээний тэмдэглэл бичээгүй байжээ.

— Мөнхүү нийгэмлэгийн тэргүүлэгчдийн 1912 оны 10-р сарын 26-ны хурлын протоколд, С. Пэлзи-гийн илтгэлд хамаарагдах нийтлэлүүдийг сэтгүүлд гаргавал зохино гэж тэмдэглээд, тэр нь 4—5 хэвлэлийн хуудас, 83 фото зураг, 52 зурмал зураг, 1 газрын зурагтай гэсэн байна.

-Хуучны юмсын үндэсний албаны («Персоналиа») архив дахь 1916 оны цуглуулгын С. Пэлзи-гийн ховор юмсын жагсаалтад «1909 онд Хойт Монголд хийсэн шинжилгээний аялалын тэмдэглэл»-ийг цаашид герман хэлээр орчуулах болно гэсэн байв.

-Энэхүү бүтээлд эргэлт болсон нэгэн зүйлийг тус нийгэмлэгийн 1920 оны 10-р сарын 29-ны протоколын 7-р зүйлд тэмдэглэхдээ: С. Пэлзи-гийн гар бичмэлийн герман орчуулгыг д-р Густав Шмидт дайны олзлогдогч байх үедээ алга болгочихсоныг лавлан мэдэх зорилт тавьжээ.

-Тэр лавлагааны хариу болгон Г. Шмидтээс 1920 оны 11-р сарын 15-нд тус нийгэмлэгийн захиргаанд өгсөн тайлбарт бичихдээ: д-р Пэлзи-гийн гар бичмэлийн герман орчуулгыг би тэр үед, д-р Каряланпенд өгсөн. Түүнд зориулсан шагналын мөнгөний тооцоог ч хүлээн авч байснаа санаж байна. Харин тэр үед Пэлзи аялалд явчихсан байсан тул харилцаж чадаагүй юм гэжээ. Гэвч түүнээс хойш, тус нийгэмлэгийн ажлын протоколд энэхүү асуудлаар ямар ч мэдээлэл байхгүй болчихсон байна. (8-9-р талд)

Түүнээс хойш 60 гаруй жил өнгөрч, нэрт эрдэмтэн Сакари Пэлзи*-гийн төрсний 100 жилийн ойг тэмдэглэхээр орон даяар бэлтгэж байсан 80-аад оны эхээр, түүний Монголд хийсэн аялалын тэмдэглэл, тайлбар, авсан фото зургуудийн хувь заяаг эрж хайх ажил эхэлсэн ба харин архиваас нилээд зүйл олсон байна. Тухайлбал; 1981 оны хавар, С. Пэлзигийн аялалын өдрийн тэмдэглэл гурван дэвтэр, нимгэн цаасан дээр хийсэн археологи, угсаатны зүйн багц зураглал, явсан замын зураг-герман хэлээрх тайлбарын хамт, фото зургууд ба зурмал зургийн хэвлэлийн барын анхны дардас болон авсан зургуудынх нь хувилбарууд, аялалын эрдэм шинжилгээний тэмдэглэлийн анхны гар бичмэл 96 хуудас-герман орчуулгын хамт, цаашид фин хэлээр чернилээр сийрэг бичсэн ерөнхий гар бичмэл 160 хуудас, гарчигтайгаа байжээ. (9-р талд)

Хэдийгээр тэрхүү олдсон хоёр эхийн төгсгөлийн хуудсууд үрэгдсэн боловч, аялалынх нь өдрийн тэмдэглэлээс нөхөн гүйцээж чадсан байна. Ийнхүү финландийн нэрт эрдэмтэн С. Пэлзи-гийн Монголд хийсэн 1909 оны шинжилгээний аялалын тэмдэглэл анх удаа бүрэн эхээрээ олон улсын уншигчид ба монгол судлаачдад зориулагдан 1982 онд Хельсинкид герман хэлээр хэвлэгдэж, нийтийн хүртээл боллоо,

«С. Пэлзи-гийн эрин зууны дурсамж» гэсэн энэхүү ном нь: оршил, зохиогчидын намтарын хуудас, бүтээлийн жагсаалтаас гадна, 1909 онд хойт Монголд хийсэн шинжилгээ хайгуулынхаа тухай, С. Пэлзи, Г. Ж. Рамстедт нарын тэмдэглэлүүдийг нийтэлжээ. Уг бүтээлийн «Археологийн талаар» гэсэн эхний хэсэг нь: 6 бүлэг, 1-62 зүйлтэй: «Угсаатны зүйн талаар» гэсэн хоёр дахь хэсэг нь: 6 бүлэг 63-98 зүйл тэй бөгөөд төгсгөлдөө, дүгнэлтийн зохиолууд болон 1-ээс 263 гэж дэс дугаарласан фото зургуудыг товч тайлбартайгаар хавсаргасан байна. Тэдгээрийн дотроос, мөнхүү бүтээлийн гарчигийг бүрэн эхээр нь, оршил ба аялалын тэмдэглэлээс тухайн үед Монголын түүхэнд холбогдох материалуудын товчилсон орчуулга, хавсралт зургийн тайлбаруудыг ДДСХ-ийн тусгай фондын материалд нийлүүлэв.

*Сакари Пэлзи 1882 оны 7-р сарын 9-нд төрөөд 1965 оны 4-р сарын 22-нд Хельсинкид нас нөхцжээ.

Манай оронд өөрчлөлт шинэчлэлтийн бодлого нийгмийн шинжлэх ухааны салбарыг ч нэгэн адил хамарч байна. Үүнтэй холбогдуулан үзэхэд одоогоос 80 жилийн өмнө манай орны нийгэм, түүхэн хөгжил, археологи, угсаатны зүйн талаар, тэр үеийн монголын улс төр-шашны төв өргөө (одоогийн Улаанбаатар) болон Түшээт хан, Сайн ноёнхан аймгийн өргөн уудам нутагт хийсэн, финландын нэрт судлаач д-р С. Пэлзигийн шинжилгээний аялалын баялаг материалыг нарийвчлан эргэж үзвэл, манай түүхчид, археологчид, угсаатны зүйн судлаачид, төв ба орон нутгийн музейн судлаачидад тухайн үеийн бодит байдалд холбогдолтой чухал баримт материал гарч болохоор санагдана.

Түүхийн талаар: Манжийн колоничлолын 200 гаруй жилийн дарлалын эсрэг өрнөсөн 1911 оны үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний нийгмийн сэтгэлгээ бүрэлдэн бэлтгэгдэж байсан тухайн үед, түүний удирдлагын томоохон төлөөлөгч Чин ван Ханддорж, Да лам Цэрэнчимэд, өвөр монголын Хайсан гүн нартай биечлэн уулзсан С. Пэлзи, 1900 ба 1909 онд удаа дараалан уулзалдсан Г. Ж. Рамстедт нарын өдрийн тэмдэглэлийг нарийвчлан үзвэл, нэн чухал түүхэн баримт ба үнэлэлт дүгнэлтийн ул мөр гарч болох юм.

Археологийн талаар: Манай оронд элбэг боловч, түүхэн бодит үнэнийх нь нууц одоо ч гүйцэд тайлагдаагүй байгаа, бичигт чулуун хөшөө, хүн чулуунууд ба хадны зургууд олон байгаа билээ. Зөвхөн тэдгээрийн тэр үед авсан зургуудыг одоогийн байгаа байдалтай нь харьцуулан судлахад л юу байсан, юу эвдэрч үгүй болсон ба үрэгдэж өөрчлөгдсөнийг ялган тодруулж болох байна.

Угсаатны зүй ба музейн талаар: Тухайн түүхэн үед бүтнээрээ байсан Ханд чин вангийн хүрээ, хойт зүгт байдаг жаргалын орон Шамбалыг мөрөөдсөний бэлэг тэмдэг-хиймэл уулан дээр барьсан дурсгалын сүм, мөн Зая бандитын хүрээний фото зургууд, ялангуяа Ламын Гэгээний хийдийн авсаархан цэмцгэр дан төвд барилгууд нь алган дээр байгаа мэт илхэн харагдаж байна. Мөн Өргөө (Хүрээ) хотын түүхт сүм дуганууд, Монгол албан байгууллага ба худалдааны төрөлжсөн захууд, манж амбаны хувийн сууцны бүрэн зураг зургууд нь Улаанбаатар хотын музейн санд төдийлөн тодорхой тайлбартай байдаггүй билээ. Мөнхүү судлаачид хүрээний нийтийн зах ба «Бээжин дэлгүүр»-ээс худалдан авч, финландын музейд өгсөн эд өглөгийн зүйлүүдэд ч сонирхолтой юмс байна. Тухайлбал: Эрт дээр үеэс Монгол мөргөлчид Баруун Зуу буюу Лхас очихдоо байнга дайран гарч байсан нандин хийдийн нэг Утайн байдлыг өнгө будагтай зурж, гурван хэлээр тайлбар бичсэн, 165x118 см хэмжээтэй 1846 оны зураг оржээ. Мөн тэр үед аялагчдын цуглуулсан монгол яруу найраг ба пянзанд бичиж авсан ардын дуу хөгжмийн бичлэгүүд ч байсан байна. Харамсалтай нь тэдгээр ардын дуу хөгжмийн бичлэг Вена хотын дууны архивт өгөгдсөн боловч дайнд тэр архив сүйрэхэд үрэгджээ. Харин яруу найргийн эх бичгүүд мөнхүү аялалын нэгэн гишүүн Г. Ж. Рамстедтын цуглуулга хойт Монголын ардын яруу найраг I, II боть болон 1973-1974 онд Хельсинкид хэвлэгдсэн байна.

Ч. БЯМБА